ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/161/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2025 он | Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Болдбаатар<br>Утас: 99105506<br>Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn<br>Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор: Б.Цэрэндэжид<br>Утас: 99812811<br>Цахим хаяг: tserendejid1109@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
   4.1 Ерөнхий зүйл ....13
   4.2 Материаллаг байдал ....14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 80

танай ______ -ны № ______ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ХҮҮХДИЙН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ш.ДОРЖХАНД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн нь 2024 онд Улсын төсвөөс 512,796.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 36,123.2 мянган төгрөгийн санхүүжилттэй, 105,901.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, төгрөгийн авлага, 1,063.8 төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилтийг улирал тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн ажилласан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 4 дүгээр улирлын байдлаар 92 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 31 нэр төрлийн 52,935.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 онд төсвийн хөрөнгөөр 1,940.0 мянган төгрөгийн өнгөт принтер, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 15,031.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад хандив тусламжаар 4,260.0 мянган төгрөгийн хөлдөөгч, ханын шкаф нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**2024 оны 12 дугаар сарын 31**
**/төгрөгөөр/**

| | Үзүүлэлт | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 108,168,611.20 | 174,894,171.20 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 51,151,458.00 | 105,901,720.00 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 51,151,458.00 | 105,901,720.00 |
| 9 | Төгрөг | 51,151,458.00 | 105,901,720.00 |
| 10 | Төрийн сангийн харилцах | 51,151,458.00 | 105,901,720.00 |
| 27 | АВЛАГА | - | 10,000.00 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 10,000.00 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 57,017,153.20 | 68,982,451.20 |
| 61 | Түүхий эд материал | 887,500.00 | 863,500.00 |
| 63 | Эм боох материал | 887,500.00 | 863,500.00 |
| 66 | Хангамжийн материал | 56,129,653.20 | 68,118,951.20 |
| 67 | Бичиг хэргийн материал | 449,300.00 | 733,200.00 |
| 70 | Түлш шатах тослох материал | 1,125,000.00 | 8,321,000.00 |
| 71 | Барилгын засварын материал | 1,466,000.00 | 1,506,500.00 |
| 72 | Хүнсний материал | 4,317,105.00 | 5,028,255.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 48,772,248.20 | 52,529,996.20 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 51,953,373.62 | 65,188,426.08 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 51,953,373.62 | 65,188,426.08 |
| 108 | Биет хөрөнгө | 38,761,373.62 | 51,996,426.08 |
| 109 | Барилга, байгууламж | 22,359,800.00 | 22,359,800.00 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | (22,359,800.00) | (22,359,800.00) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 36,541,219.00 | 54,352,829.00 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (19,028,620.08) | (23,659,543.92) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 997,800.00 | 4,417,800.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (997,800.00) | (997,800.00) |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 37,833,736.00 | 37,833,736.00 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | (16,584,961.30) | (19,950,595.00) |
| 126 | Биет бус хөрөнгө | 13,192,000.00 | 13,192,000.00 |
| 127 | Програм хангамж | 1,850,000.00 | 1,850,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 128 | Хасагдуулга | (1,850,000.00) | (1,850,000.00) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 13,192,000.00 | 13,192,000.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 160,121,984.82 | 240,082,597.28 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 199,789.00 | 1,063,789.00 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 199,789.00 | 1,063,789.00 |
| 164 | Өглөг | 199,789.00 | 1,063,789.00 |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 199,789.00 | 199,789.00 |
| 170 | Бусад өглөг | - | 864,000.00 |
| 171 | Байгууллагад төлөх өглөг | - | 864,000.00 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 159,922,195.82 | 239,018,808.28 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 159,922,195.82 | 239,018,808.28 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 13,192,000.00 | 13,192,000.00 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 13,192,000.00 | 13,192,000.00 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 124,370,395.82 | 203,467,008.28 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 124,370,395.82 | 124,370,395.82 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | 79,096,612.46 |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22,359,800.00 | 22,359,800.00 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 160,121,984.82 | 240,082,597.28 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 368,455,595.00 | 571,535,910.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,782,995.00 | 22,616,610.00 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 10,782,995.00 | 22,616,610.00 |
| 93 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө | 10,012,819.00 | 19,291,610.00 |
| 94 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал | 770,176.00 | 3,325,000.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 357,672,600.00 | 548,919,300.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 341,461,600.00 | 512,796,100.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 341,461,600.00 | 512,796,100.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 16,211,000.00 | 36,123,200.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,211,000.00 | 36,123,200.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 349,311,745.20 | 492,983,797.54 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 349,311,745.20 | 492,983,797.54 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 349,311,714,20 | 484,855,248.03 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 248,178,789.00 | 360,832,571.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 151 | Цалин | 174,941,553.00 | 232,551,979.00 |
| 152 | Нэмэгдэл цалин | 62,188,287.00 | 118,959,601.00 |
| 154 | Урамшуулал | 11,048,949.00 | 9,320,991.00 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,430,871.00 | 46,596,177.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 21,469,197.22 | 31,370,732.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,525,787.41 | 3,801,390.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,969,716.04 | 3,136,364.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 502,589.12 | 1,771,001.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,963,581.21 | 6,516,690.00 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,558,469.00 | 18,709,350.49 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 2,865,419.00 | 3,002,350.49 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 16,333,050.00 | 15,347,000.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 360,000.00 | 360,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | - | 4,667,852.00 |
| 178 | Бараа материал актасны зардал | - | 4,667,852.00 |
| 181 | Нормативт зардал | 28,063,965.00 | 33,982,700.00 |
| 183 | Хоол | 28,063,965.00 | 33,982,700.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,659,000.00 | 1,959,500.00 |
| 189 | Урсгал засвар | 1,659,000.00 | 1,959,500.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 613,900.00 | 684,400.00 |
| 200 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 613,900.00 | 684,400.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,806,720.20 | 17,422,697.54 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,871,900.00 | 7,030,790.00 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,752,200.00 | 1,850,850.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,182,620.20 | 7,996,557.54 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31.00 | 8,128,549.51 |
| 242 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 31.00 | 8,128,549.51 |
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31.00 | 8,128,549.51 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 19,143,849.80 | 79,096,612.46 |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 19,143,849.80 | 79,096,612.46 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 357,672,600.00 | 548,919,300.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 357,672,600.00 | 548,919,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 341,461,600.00 | 512,796,100.00 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 341,461,600.00 | 512,796,100.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 16,211,000.00 | 36,123,200.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,211,000.00 | 36,123,200.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 337,075,211.00 | 492,229,038.00 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 337,075,211.00 | 492,229,038.00 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 337,075,180.00 | 484,100,488.49 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 247,276,433.00 | 360,779,185.00 |
| 151 | Үндсэн цалин | 169,437,215.00 | 232,498,593.00 |
| 152 | Нэмэгдэл | 67,068,349.00 | 118,959,601.00 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 10,770,869.00 | 9,320,991.00 |
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 32,133,438.00 | 46,659,563.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 21,850,518.00 | 30,734,157.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,570,631.00 | 3,801,390.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,056,483.00 | 3,136,364.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 514,244.00 | 1,771,001.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,141,562.00 | 7,216,651.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 14,210,969.00 | 25,994,650.49 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 2,865,419.00 | 3,002,350.49 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 10,985,550.00 | 22,632,300.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 360,000.00 | 360,000.00 |
| 181 | Норматив зардал | 29,305,540.00 | 34,693,850.00 |
| 183 | Хоол, хүнс | 29,305,540.00 | 34,693,850.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 189 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 613,900.00 | 1,703,100.00 |
| 200 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 613,900.00 | 1,703,100.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,534,900.00 | 12,270,140.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,753,200.00 | 7,427,340.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,781,700.00 | 4,842,800.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31.00 | 8,128,549.51 |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 31.00 | 8,128,549.51 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31.00 | 8,128,549.51 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 20,597,389.00 | 56,690,262.00 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 1,940,000.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 1,940,000.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | - | 1,940,000.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 1,940,000.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | (1,940,000.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 20,597,389.00 | 54,750,262.00 |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 30,554,069.00 | 51,151,458.00 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 51,151,458.00 | 105,901,720.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 0 | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| 2 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 13192000.00 | 22359800.00 | 105226546.02 | 140778346.02 |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13192000.00 | 22359800.00 | 105226546.02 | 140778346.02 |
| 5 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 19143849.80 | 19143849.80 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 13192000.00 | 22359800.00 | 124370395.82 | 159922195.82 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 13192000.00 | 22359800.00 | 124370395.82 | 159922195.82 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13192000.00 | 22359800.00 | 124370395.82 | 159922195.82 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 79096612.46 | 79096612.46 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 13192000.00 | 22359800.00 | 203467008.28 | 239018808.28 |

## 2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / үндсэн санхүүжилт /

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 51,151,458.00 | (51,151,458.00) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 555,753,800.00 | 458,045,838.00 | 97,707,962.00 | 82.42 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 555,753,800.00 | 458,045,838.00 | 97,707,962.00 | 82.42 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 555,753,800.00 | 458,045,838.00 | 97,707,962.00 | 82.42 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 444,330,700.00 | 360,779,185.00 | 83,551,515.00 | 81.20 |
| 6 | Үндсэн цалин | 303,546,800.00 | 232,498,593.00 | 71,048,207.00 | 76.59 |
| 7 | Нэмэгдэл | 139,446,700.00 | 118,959,601.00 | 20,487,099.00 | 85.31 |
| 9 | Урамшуулал | 1,337,200.00 | 9,320,991.00 | (7,983,791.00) | 697.05 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,994,600.00 | 46,659,563.00 | 5,335,037.00 | 89.74 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 35,357,200.00 | 30,734,157.00 | 4,623,043.00 | 86.92 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 4,158,700.00 | 3,801,390.00 | 357,310.00 | 91.41 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 2,079,800.00 | 3,136,364.00 | (1,056,564.00) | 150.80 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 2,079,800.00 | 1,771,001.00 | 308,799.00 | 85.15 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 8,319,100.00 | 7,216,651.00 | 1,102,449.00 | 86.75 |
| 30 | Нормативт зардал | 39,315,000.00 | 34,693,850.00 | 4,621,150.00 | 88.25 |
| 32 | Хоол, хүнс | 39,315,000.00 | 34,693,850.00 | 4,621,150.00 | 88.25 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 1,703,100.00 | 1,703,100.00 | - | 100.00 |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 1,703,100.00 | 1,703,100.00 | - | 100.00 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,410,400.00 | 14,210,140.00 | 4,200,260.00 | 77.19 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,567,600.00 | 9,367,340.00 | 4,200,260.00 | 69.04 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,842,800.00 | 4,842,800.00 | - | 100.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 555,753,800.00 | 512,796,100.00 | 42,957,700.00 | 92.27 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 555,753,800.00 | 512,796,100.00 | 42,957,700.00 | 92.27 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 555,753,800.00 | 512,796,100.00 | 42,957,700.00 | 92.27 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 51,151,458.00 | (51,151,458.00) | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 105,901,720.00 | (105,901,720.00 ) | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 131 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 15.00 | 15.00 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 | 7.00 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | - | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дундаж/ | 120.00 | 120.00 | - | 100.00 |
| 142 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | 120.00 | 120.00 | - | 100.00 |

### 2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / нэмэлт санхүүжилт /

| SORT_ID | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 36,123,200.00 | 27,994,650.49 | 8,128,549.51 | 77.50 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 36,123,200.00 | 27,994,650.49 | 8,128,549.51 | 77.50 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 36,123,200.00 | 27,994,650.49 | 8,128,549.51 | 77.50 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 34,123,200.00 | 25,994,650.49 | 8,128,549.51 | 76.18 |
| 18 | Гэрэл цахилгаан | 13,251,000.00 | 3,002,350.49 | 10,248,649.51 | 22.66 |
| 19 | Түлш, халаалт | 19,662,200.00 | 22,632,300.00 | (2,970,100.00) | 115.11 |
| 20 | Цэвэр, бохир ус | 1,210,000.00 | 360,000.00 | 850,000.00 | 29.75 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| 38 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 36,123,201.00 | 27,994,650.49 | 8,128,550.51 | 77.50 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 36,123,201.00 | 27,994,650.49 | 8,128,550.51 | 77.50 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 36,123,201.00 | 27,994,650.49 | 8,128,550.51 | 77.50 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 131 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 15.00 | 15.00 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 | 7.00 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | - | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 120.00 | 120.00 | - | 100.00 |
| 142 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | 120.00 | 120.00 | - | 100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:**

- Сургуулийн өмнөх боловсрол олгох

**Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн зорилго**: Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах.

2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал

тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн ажилласан байна. 4-р улирлын байдлаар төлөвлөгөөний гүйцэтгэлийн биелэлт 92% байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:** 2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлыг хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 05 сарын 29-ний 237 дугаар тогтоолоор "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1,3 "Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна гэсний дагуу байгууллагын дотоод хяналтын комиссыг 2024 оны 09 сарын 02-ны А/12 тушаалаар шинэчлэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Журмаа шинэчлэн боловсруулж улирал бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнаж ажилладаг. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаархи нийт хөрөнгө өмнөх оноос 79,960.7 мянган төгрөгөөр буюу 66.6 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1.** Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0.00 | 10.00 | 10.00 |
| Бараа материал | 57,017.2 | 68,982.5 | 11,965.3 |
| Үндсэн хөрөнгө | 112,774.6 | 134,006.2 | 21,231.6 |
| **Нийт хөрөнгө** | **160,122** | **240,082.6** | **79,960.6** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 160,122 | 240,082.6 | 79,960.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **160,122** | **240,082.6** | **79,960.6** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 57,017.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 70,241 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 3,325.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 61,600.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 68,982.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,965.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 1,940.00 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БГазар, эцэг эхчүүдийн хөрөнгө оруулалтаар 19,291.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж жилийн эцэст 134,006.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 7,996.6 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 239,018.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 497,854.5 мянган төгрөг, нийт зарлагыг 497,854.5 мянган төгрөг тооцоолон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 512,796.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,123.2 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл улсын төсвийн гүйцэтгэл 492,229.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Жилийн эцэст гүйлгээ хаасны дараа санхүүжилт нэмж олгосон байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71801** | **Сургуулийн өмнөх боловсрол** | | | | |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 747.8 | 747.8 | - | 100% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 1,301.0 | 750.00 | 551.0 | 57.6% |
| 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 38,206.2 | 34,693.9 | 3,512.3 | 90.8% |
| 81816 | Хүүдэд ээлтэй сургалын орчин | 1,940.00 | 1,940.0 | - | 100% |
| 81823 | Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх зардал | 1,110.20 | 380.3 | 729.9 | 34.2% |
| 81832 | Нүүдлийн бүлэгт хамааруулах | 10,018.90 | - | 10,018.90 | - |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 466,897.60 | 419,533.9 | 47,363.7 | 89.9% |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 36,123.2 | 36,123.2 | - | 100% |
| | **НИЙТ ДҮН** | **548,919.3** | **492,229.0** | **56,690.3** | **89.67%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 36,123.2 төгрөг төвлөрүүлсэнээс , төсвийн гүйцэтгэл 27,994,7 мянган төгрөг зарцуулсан байна. Гэрэл цахилгаан , түлш халаалт , цэвэр бохир ус, урсгал засварт зарцуулж 8,128.5 төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Хоол хүнс | 39,315.0 | 35,121.8 |
| 2 | Шууд худалдан авалт | Хичээл практик | 4,842.8 | 4,842.8 |
| 3 | Шууд худалдан авалт | Бараа үйлчилгээний зардал | 13,567.6 | 9,367.3 |
| 4 | Шууд худалдан авалт | Мэдээллийн технологийн зардал | 1,703.1 | 1,703.1 |
| **ДҮН** | | | **59,428.5** | **51,035** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 492,439.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,386.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,539.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил дутагдал илрээгүй. Акт, зөвлөмж , албан шаардлага аваагүй.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0 мянган төгрөгийн 1 алдаанд зөвлөмж өглөө.

***Залруулсан алдаа:байхгүй***

**Шийдвэрлэсэн байдал:** Байхгүй

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

### 5.3 Зөвлөмж

***Илэрсэн алдаа:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 31 төрлийн 52,935.69 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 31 нэр төрлийн 52,935,695.00 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 31 | | | | | | | | | | | |
| **Дүн** | **31** | | | | | | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-01

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-02-01